



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, Эрх чөлөөний өргөн чөлөө-3,
Уртбулаг баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033

Утас: (976) 7035 9826

Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2026.02.10 № 72
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН ГАЗРЫН
ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Р.ГАЛБААТАР ТАНАА

**2025 оны санхүүгийн тайлангийн
аудитын тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд баталгаажуулах аудит хийлээ.

Аудитын тайлан, аудитын дүгнэлт болон аудитаар илэрсэн 4,191.7 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгч байна.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасныг хэрэгжүүлж албан шаардлага, зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА

612505230



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 дугаар 12 сарын

Дугаар 62/А1470340
ОРА-2026/040/НА-СТА-ТЦЗ

Баян-Өндөр сум

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, тайлант онд зарцуулсан 1,150,000 (Нэг сая нэг зуун тавин) мянган төгрөгийн шатахууныг бодитоор тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, шатахууныг бодитоор тайлагнаагүй зөрчлийг таслан зогсоож, шатахууныг бодитой

612509192

тайлагнаж биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орхон аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Р.Галбаатар), нягтлан бодогч (Б.Ариунцэцэг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР..... П.ПҮРЭВЛХАГВА

АУДИТЫН
МЕНЕЖЕР..... Б.БУЯН-УНДРАХ

АУДИТОР..... О.ГАНТУЯА



¹ Монгол улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хүрэнбулаг баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-9826

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2026/040/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Орхон аймаг
2026 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва
Утас: 70353088 Цахим хаяг: purevlkhagvap@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Аудитор: О.Гантуяа
Утас: 70350757 Цахим хаяг: gantuyao@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	16
5.1 Төлбөрийн акт	16
5.2 Албан шаардлага	18
5.3 Зөвлөмж.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЗГНХ,ЗДНХөрөнгө	Засгийн газрын нөөц хөрөнгө, Засаг даргын нөөц хөрөнгө
УТ	Улсын төсөв
ОНТ	Орон нутгийн төсөв
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, Эрх чөлөөний өргөн чөлөө-3,

Уртбулаг баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033

Утас: (976) 7035 9826

Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2026.02.11 № 41
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Орхон аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар 56,135.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, эд хогшил шилжүүлэн авч, бүртгэл тайланд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Усан сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийг тогтоох ажлын хүрээнд 4,665.2 га газрыг хэмжиж, зурагжуулсан байна.

Бусад асуудал

Тайлант онд 4 зорилт, 120 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг 98.4 хувьтай үнэлүүлсэн байна.

612505245

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	148,909,765.00	159,009,571.44
33	АВЛАГА	41,292,075.00	52,724,531.44
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	41,292,075.00	52,724,531.44
35	БАРАА МАТЕРИАЛ	97,461,540.00	106,285,040.00
351	Түүхий эд материал	87,600,000.00	87,600,000.00
35110	Тусгай зориулалттай материал	87,600,000.00	87,600,000.00
354	Хангамжийн материал	9,861,540.00	18,685,040.00
35410	Бичиг хэргийн материал	4,477,750.00	3,859,200.00
35420	Аж ахуйн материал	5,383,790.00	4,669,690.00
35470	Бусад хангамжийн материал	10,156,150.00	10,156,150.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	359,356,924.66	392,255,603.78
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	359,356,924.66	392,255,603.78
392	Биет хөрөнгө	325,835,258.07	359,063,937.19
39203	Авто-тээврийн хэрэгсэл	16,918,686.90	16,918,686.90
39204	Хуримтлагдсан элэгдэл	-6,767,474.88	-10,151,212.32
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	442,750,137.95	478,561,072.74
39206	Хуримтлагдсан элэгдэл	-158,245,641.74	169,111,074.07
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	44,633,907.50	56,760,367.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-13,454,357.66	-13,913,903.56
393	Биет бус хөрөнгө	33,521,666.59	33,191,666.59
39301	Програм хангамж	1,760,000.00	1,760,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-238,333.41	-568,333.41
39303	Бусад биет бус хөрөнгө	32,000,000.00	32,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	498,110,539.66	551,265,175.22
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	508,266,689.66	551,265,175.22
51	Засгийн газрын хувь оролцоо	508,266,689.66	551,265,175.22
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	190,706,338.05	190,706,338.05
51101	Өмч: - төрийн	190,706,338.05	190,706,338.05
512	Хуримтлагдсан үр дүн	317,560,351.61	360,558,837.17
51210	Өмнөх үеийн үр дүн	317,560,351.61	360,558,837.17
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	508,266,689.66	551,265,175.22

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,565,135,352.25	1,478,803,656.52
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	359,031,875.00	247,258,212.68
120	Нийтлэг татварын бус орлого	359,031,875.00	247,258,212.68
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	359,031,875.00	247,258,212.68
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	83,382,875.00	113,151,003.44
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	275,649,000.00	134,107,209.24
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,206,103,477.25	1,231,545,443.84

1310	Улсын төвлөрсөн төсвөөс	927,853,100.00	1,085,982,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	927,853,100.00	1,085,982,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	277,228,060.00	144,238,043.84
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	141,195,060.00	144,238,043.84
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,300,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	133,733,000.00	
1330	Төсвийн захирагчдаас	1,022,317.25	1,325,400.00
133003	Хөрөнгийн	1,022,317.25	1,325,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,366,732,839.91	1,435,613,980.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,366,732,839.91	1,435,613,980.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,131,703,699.42	1,299,803,239.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	830,836,729.37	946,790,455.41
210101	Үндсэн цалин	377,600,917.36	446,986,379.61
210102	Нэмэгдэл	291,270,812.01	306,014,075.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	103,400,000.00	125,685,000.00
210104	Урамшуулал	58,565,000.00	68,105,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	104,850,191.86	118,902,664.19
210201	Тэтгэврийн даатгал	71,513,554.54	80,918,438.58
210202	Тэтгэмжийн даатгал	8,413,359.36	9,519,816.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,153,879.66	4,744,068.23
210204	Ажилгүйдлийн даатгал	4,153,879.66	4,744,068.23
210205	Эрүүл мэндийн даатгал	16,615,518.64	18,976,272.67
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,322,297.93	71,015,790.14
210301	Гэрэл, цахилгаан	3,949,909.92	5,524,350.37
210302	Түлш, халаалт	3,043,798.06	2,748,866.10
210303	Цэвэр, бохир ус	784,859.95	757,809.67
210304	Байрны түрээс	56,543,730.00	61,984,764.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,659,745.85	14,313,376.00
210401	Бичиг хэрэг	15,922,317.25	7,444,050.00
210402	Тээвэр, шатахуун	4,060,000.00	2,030,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,826,728.60	2,331,226.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	306,000.00	360,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,544,700.00	1,848,600.00
210408	Бараа материал акталсны зардал		299,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	818,000.00	0.00
210604	Урсгал засвар	818,000.00	
2107	Томилот, зочны зардал	880,000.00	3,147,800.00
210702	Дотоод албан томилот	880,000.00	3,147,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,033,437.35	14,883,113.81
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,851,137.35	13,451,138.81
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	70,600.00	456,175.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		46,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	7,700.00	29,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		660,000.00
210807	Газрын төлбөр	240,000.00	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	91,303,297.06	130,750,039.71
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		29,782,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хөрогдол	91,303,297.06	100,967,339.71
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	192,322,874.89	135,810,741.29
2132	Бусад урсгал шилжүүлэг	56,104,990.54	57,178,257.75
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,800,200.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		31,621,257.75
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	36,967,290.54	25,557,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,337,500.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,157,663.32	78,632,483.54
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,157,663.32	78,632,483.54
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	133,733,746.63	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	133,733,746.63	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>198,402,512.34</u>	<u>43,189,675.97</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	191,190.41
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		191,190.41
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	-191,190.41
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>198,402,512.34</u>	<u>42,998,485.56</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,276,129,925.60</u>	<u>1,331,438,590.84</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	71,048,765.60	101,218,547.00
120	Нийтлэг татварын бус орлого	71,048,765.60	101,218,547.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	71,048,765.60	101,218,547.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	71,048,765.60	101,218,547.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,205,081,160.00	1,230,220,043.84
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	927,853,100.00	1,085,982,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	927,853,100.00	1,085,982,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	277,228,060.00	144,238,043.84
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	141,195,060.00	144,238,043.84

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,300,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	133,733,000.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,272,648,025.60	1,331,438,590.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,272,648,025.60	1,331,438,590.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,079,651,625.11	1,195,627,849.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	830,836,729.37	946,790,455.41
210101	Үндсэн цалин	377,600,917.36	449,160,574.32
210102	Нэмэгдэл	291,270,812.01	304,977,419.84
210103	Унаа хоолны хөнгөлөлт	103,400,000.00	124,932,211.25
210104	Урамшуулал	58,565,000.00	67,720,250.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	104,850,191.86	118,902,664.19
210201	Тэтгэврийн даатгал	71,513,554.54	80,918,438.58
210202	Тэтгэмжийн даатгал	8,413,359.36	9,519,816.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,153,879.66	4,744,068.23
210204	Ажилгүйдлийн даатгал	4,153,879.66	4,744,068.23
210205	Эрүүл мэндийн даатгал	16,615,518.64	18,976,272.67
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,322,297.93	71,015,790.14
210301	Гэрэл, цахилгаан	3,949,909.92	5,524,350.37
210302	Түлш, халаалт	3,043,798.06	2,748,866.10
210303	Цэвэр, бохир ус	784,859.95	757,809.67
210304	Байрны түрээс	56,543,730.00	61,984,764.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/		
2104	Хангамж, бараа материалын зардал	2,764,028.60	6,778,926.00
210401	Бичиг хэрэг		1,403,700.00
210402	Тээвэр, шатахуун	99,000.00	1,980,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,826,728.60	2,331,226.00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	306,000.00	360,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	532,300.00	704,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	71,600.00	0.00
210604	Урсгал засвар	71,600.00	
2107	Томилолт, зочны зардал	880,000.00	3,147,800.00
210702	Дотоод албан томилолт	880,000.00	3,147,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,033,437.35	14,883,113.81
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,851,137.35	13,451,138.81
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	70,600.00	456,175.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		46,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	7,700.00	29,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		660,000.00
210807	Газрын төлбөр	240,000.00	240,000.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	34,109,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		34,109,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	192,996,400.49	135,810,741.29
2132	Бусад урсгал шилжүүлэг	56,104,990.54	57,178,257.75
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,800,200.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		31,621,257.75
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	36,967,290.54	25,557,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,337,500.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,484,137.72	78,632,483.54
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,484,137.72	78,632,483.54
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	133,733,746.63	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	133,733,746.63	
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,481,900.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,481,900.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,481,900.00	0.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,481,900.00	
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-3,481,900.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	190,706,338.05		119,157,839.27	309,864,177.32
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	190,706,338.05	0.00	119,157,839.27	309,864,177.32
C07	Тайлант үеийн үр дүн			198,402,512.34	198,402,512.34
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	190,706,338.05	0.00	317,560,351.61	508,266,689.66
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	190,706,338.05	0.00	317,560,351.61	508,266,689.66
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	190,706,338.05	0.00	317,560,351.61	508,266,689.66
D08	Тайлант үеийн үр дүн			42,998,485.56	42,998,485.56
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	190,706,338.05	0.00	360,558,837.17	551,265,175.22

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,007,853,100.00	995,744,202.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,007,853,100.00	995,744,202.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	954,032,400.00	941,939,211.74

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	34,109,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		34,109,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	192,996,400.49	135,810,741.29
2132	Бусад урсгал шилжүүлэг	56,104,990.54	57,178,257.75
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,800,200.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		31,621,257.75
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	36,967,290.54	25,557,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,337,500.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,484,137.72	78,632,483.54
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,484,137.72	78,632,483.54
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	133,733,746.63	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	133,733,746.63	
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,481,900.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,481,900.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,481,900.00	0.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,481,900.00	
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-3,481,900.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	190,706,338.05		119,157,839.27	309,864,177.32
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	190,706,338.05	0.00	119,157,839.27	309,864,177.32
C07	Тайлант үеийн үр дүн			198,402,512.34	198,402,512.34
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	190,706,338.05	0.00	317,560,351.61	508,266,689.66
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	190,706,338.05	0.00	317,560,351.61	508,266,689.66
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	190,706,338.05	0.00	317,560,351.61	508,266,689.66
D08	Тайлант үеийн үр дүн			42,998,485.56	42,998,485.56
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	190,706,338.05	0.00	360,558,837.17	551,265,175.22

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,007,853,100.00	995,744,202.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,007,853,100.00	995,744,202.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	954,032,400.00	941,939,211.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	706,528,300.00	705,330,673.03

210101	Үндсэн цалин	376,996,000.00	377,600,917.36
210102	Нэмэгдэл	167,547,300.00	165,764,755.67
210103	Унаа хоолны хөнгөлөлт	103,420,000.00	103,400,000.00
210104	Урамшуулал	58,565,000.00	58,565,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	89,311,900.00	89,161,934.83
210201	Тэтгэврийн даатгал	60,947,400.00	60,845,539.74
210202	Тэтгэмжийн даатгал	7,170,300.00	7,158,298.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,532,400.00	3,526,349.37
210204	Ажилгүйдлийн даатгал	3,532,400.00	3,526,349.37
210205	Эрүүл мэндийн даатгал	14,129,400.00	14,105,397.57
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,012,900.00	64,322,297.93
210301	Гэрэл, цахилгаан	3,901,300.00	3,949,909.92
210302	Түлш, халаалт	3,598,000.00	3,043,798.06
210303	Цэвэр, бохир ус	1,969,700.00	784,859.95
210304	Байрны түрээс	56,543,900.00	56,543,730.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,764,100.00	2,764,028.60
210401	Бичиг хэрэг	440,400.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	99,000.00	99,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,808,300.00	1,826,728.60
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	306,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	416,400.00	532,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	71,600.00	71,600.00
210604	Урсгал засвар	71,600.00	71,600.00
2107	Томилолт, зочны зардал	880,000.00	880,000.00
210702	Дотоод албан томилолт	880,000.00	880,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,033,600.00	9,033,437.35
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,851,300.00	7,851,137.35
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	864,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	70,600.00	70,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	7,700.00	7,700.00
210807	Газрын төлбөр	240,000.00	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	79430000.00	70375240.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	79,430,000.00	70,375,240.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53820700.00	53804990.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	53,820,700.00	53,804,990.54
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,800,200.00	3,800,200.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх	36,967,300.00	36,967,290.54
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,053,200.00	13,037,500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,007,853,100.00	995,744,202.28
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	927,853,100.00	925,368,962.28
131001	Улсын төсвөөс санхүүжих	927,853,100.00	925,368,962.28
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	80,000,000.00	70,375,240.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	80,000,000.00	70,375,240.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	23.00	22.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	20.00	19.00
620003	Үйлчлэх ажилтан	02.00	02.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Орхон аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь газрын харилцааны болон барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн чиглэлээр төрөөс баримталж байгаа бодлого, зорилт, хөтөлбөр, тогтоол, шийдвэрүүдийг орон нутагтаа хэрэгжүүлэх, энэ чиглэлийн үйлчилгээ үзүүлэх, дээд шатны газар, албан тушаалтыг мэдээ судалгаагаар хангах, сумдын даамлуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд нь дүн шинжилгээ хийж хяналт тавих үүрэг бүхий Засаг даргын эрхлэх асуудлын хүрээн дэх хэрэгжүүлэгч харьяа агентлаг юм.

Орхон аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь салбарын хууль эрх зүй, техникийн баримт бичгийг боловсронгуй болгох, хэрэгжүүлэх, газрын шинэтгэлийн бодлогыг эрчимжүүлж, газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах, нутаг дэвсгэрийг зурагжуулах, солбицол, өндрийн нэгдсэн тогтолцоог хангах, үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтэц байгуулах, барилгажилт, барилгын материалын үйлдвэрлэл, нийтийн аж ахуйг хөгжүүлэх, хот төлөвлөлт, хот байгуулалтын бодлогыг хэрэгжүүлэх замаар салбарын үр ашиг, бүтээмж чанарыг дээшлүүлэхэд оршино.

Тус газар нь 2025 онд 4 зорилт, 120 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг 98.4 хувьтай гүйцэтгэсэн байна.

Засгийн газрын 9 тогтоолын 18 заалт, 8 тэмдэглэлийн 11 заалтыг хяналтдаа авч хэрэгжүүлж биелэлтийг Засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст, Геодези зураг зүйн газарт тус бүр хүргүүлсэн.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Орхон аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь газрын харилцааны болон барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн чиглэлээр төрөөс баримталж байгаа бодлого, зорилт, хөтөлбөр, тогтоол, шийдвэрүүдийг орон нутагтаа хэрэгжүүлэх, энэ чиглэлийн үйлчилгээ үзүүлэх, дээд шатны газар, албан тушаалтыг мэдээ судалгаагаар хангах, сумдын даамлуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд нь дүн шинжилгээ хийж, хяналт хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа дараах хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөн ажилласан байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Барилгын тухай хууль
- Газрын тухай хууль
- Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль
- Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол
- Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоол
- Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоол
- Засгийн газрын 2019 оны 5, 6, 7 дугаар тогтоол
- Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоол

- Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаал
- Сангийн сайдын 2024 оны А/52 дугаар тушаал

Тайлант онд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжид дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Барилгын тухай хуульд 1, Хот байгуулалтын тухай хуульд 1, Төрийн хэмнэлтийн тухай хуульд 1, Авилгийн эсрэг хууль 1, Захиргааны ерөнхий хуульд -1, Төсвийн тухай хуульд 3 удаагийн нэмэлт өөрчлөлт орсон байна.
- Засгийн газрын 238 дугаар тогтоолоор "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээ"-г шинэчлэн тогтоож, 2025 оны 01 дүгээр сарын 01-ээс мөрдөж эхэлсэн.
- Засгийн газрын 83 дугаар тогтоолоор "Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам", Засгийн газрын 82 дугаар тогтоолоор "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам" -ыг тус тус 2024 оны 02 дугаар сарын 28-нд баталж, мөрдсөн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагаа нь үндсэн үйл ажиллагаанд чиглэж, төсөв санхүү, нягтлан бодох бүртгэл болон шилэн данс, төрийн хэмнэлтийн хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт хийгээгүй байх тул дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийг үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Дотоод аудиторын чиг үүргийг хэрэгжүүлэх орон тоо байдаг ч гүйцэтгэсэн ажлын төлөвлөгөөний хэрэгжилт, тайланг аудитад ашиглах шаардлага үүсээгүй болно.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус газар нь Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газраас 2023 онд шинэчлэн батлуулсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг ашиглаж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Орхон аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 42,998.5 мянган төгрөгөөр буюу 8.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

			/мянган төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0

Авлага	41,292.0	52,724.5	11,432.5
Бараа материал	107,617.7	106,285.0	(1,332.7)
Үндсэн хөрөнгө	359,356.9	392,255.6	32,898.7
Нийт хөрөнгө	508,266.6	551,265.1	42,998.5
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	508,266.6	551,265.1	42,998.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	508,266.6	551,265.1	42,998.5

Дээрх хүснэгтээс харахад нийт хөрөнгө өмнөх оноос 42,998.5 мянган төгрөгөөр өсөхөд авлага, үндсэн хөрөнгийн данс нөлөөлсөн байна.

Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газраас 2025 онд хийсэн барилгын техник хяналтын зардлыг он дамжуулан тооцоо нийлснээс шалтгаалж 52,724.5 мянган төгрөгийн авлага үүсжээ.

Тайлант онд 10,419.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 11,752.1 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 106,285.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Орон нутгийн өмчийн газраас хөрөнгө оруулалтаар 56,135.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил авснаас шалтгаалж үндсэн хөрөнгийн данс өсжээ.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 12 дугаар сарын 04-ний үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай 669 дүгээр тогтоолоор тус газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 42 нэрийн нийт 78,235.9 мянган төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 71,058.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоож орлого авсан байна.

Мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 691 дүгээр тогтоолын дагуу ашиглалтын шаардлага хангахгүй 7,883.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 934,765.2 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 80,000.0 мянган төгрөг нийт 1,014,765.2 мянган төгрөгийг төлөвлөж, нийт зарлагыг 1,014,765.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас үндсэн үйл ажиллагааны зардлыг 137,376.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, улсын төсвөөс 1,062,141.4 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 90,000.0 мянган төгрөг нийт 1,152,141.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд улсын төсвөөс баталсан хуваарийг 2 удаа өөрчилж, төсвийг 23,227.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгожээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлж улсын төсвөөс 1,115,368.7 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 60,000.0 мянган төгрөгийг нийт 1,175,368.6 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,066,749.5 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Орон нутгийн төсвөөс орон нутгийн нэмэгдэл цалин, нийгмийн даатгалын шимтгэлд нийт 144,445.6 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 144,238.0 мянган төгрөгийг зарцуулж, 207.1 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Улсын төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,142,419.5 мянган төгрөг буюу 97.1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 35,248.0 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 3,643.8 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 15,935.9 мянган төгрөг, хангамжийн бараа материалын зардал 2,516.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 4,230.9 мянган төгрөг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Мөн үндсэн үйл ажиллагааны орлогоос 63,851.3 төгрөг орж, төлөвлөгөөнөөс давсан 33,851.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
УЛСЫН ТӨСӨВ					
1	71504 Газрын зураглал, кадастр				
1.1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	1,066,749.50	1,007,938.66	58,810.83	94.49%
1.2	80226 Байр ашиглалтын үйлчилгээ	16,237.40	13,451.13	2,786.26	82.84%
1.3	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	62,381.70	57,178.40	5,203.50	91.66%
1.4	82404 Барилгын техник хяналт	30,000.00	63,851.31	(33,851.31)	212.84%
	Нийт дүн	1,175,368.6	1,142,419.50	32,949.1	97.19%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансанд аймгийн ИТХ-ын 2023 оны 17/04 дүгээр тогтоолын дагуу байгууллагын албан хаагчдад орон нутгийн төсвөөс орон нутгийн нэмэгдэл цалин, шимтгэлд нийт 144,445.6 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 144,238.0 мянган төгрөгийг зарцуулж 207.1 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж, илүү дутуу зөрүүгүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд төсөл хөтөлбөр хэрэгжээгүй болно.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд үндсэн үйл ажиллагааны орлогыг 210901 зардалд хуваарилж 1,980.0 мянган төгрөгийн шатах тослох материалыг НИК ХХК-тай гэрээ байгуулж худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Орхон аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлэх, санхүүгийн бүртгэл, тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Гантуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Буян-Ундрах, дарга, тэргүүлэх аудитор П.Пүрэвхагва нар тус тус хэрэгжүүллээ.

Орхон аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2025 санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 22-ний өдрийн 40 тоот албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсөв 1,176,197.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 17,642.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд 2025 оны 12 сард тодотгосон төсвийн 1,175,368.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар хувиар буюу 17,630.5 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага нь цахим дэлгүүрээс худалдан авалт хийх шаардлага гараагүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 159 талбарын мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

Шилэн дансны хуулийн мэдээлсэн байдлын хэрэгжилт 100 хувь, хугацаа хоцролт байхгүй хэрэгжилт 100 хувьтай үнэлэгдсэн тул зөрчилгүйд тооцов.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцлийн асуудлыг үнэлэх асуудал үүсээгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Орхон аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийсэн.

Завсрын аудитаар нийт 280.0 мянган төгрөгийн 1 зөрчил илэрснээс жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлж ажилласан тул залруулагдсанд тооцов.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Орхон аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Гантуяа гүйцэтгэсэн бөгөөд аудитаар нийт 15,213.7 мянган төгрөгийн 3 зөрчил илэрснээс, 11,733.7 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 3,480.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн байна. Албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 25-ний өдөр ирүүлсэн.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0	0	0	0	00
Албан шаардлага	1	11,733.7	1	11,733.7	100.0
Зөвлөмж	2	3,480.0	1	3,480.00	100.0
Нийт дүн	3	15,213.7	2	15,213.7	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулагдсан алдаа гараагүй.

Аудитаар нийт 4,191.7 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 1,150.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 3,041.7 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгч байна.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2 Албан шаардлага

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, тайлант онд зарцуулсан 1,150.0 мянган төгрөгийн шатахууныг бодитоор тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" заалттай нийцэхгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалин, урамшуулал, нэмэгдэл хөлстэй холбоотой асуудал

Тайлант онд байгууллагын жолоочид шалгуур үзүүлэлтийн дагуу бодитой үнэлэлгүй 3,041.7 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4-р хавсралтын 3-т "Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу бодитой үнэлж өгөх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Загруулсан		Загруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Дүн													

/мянган төгрөг/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, тайлант онд зарцуулсан 1,150.0 мянган төгрөгийн шатахууныг бодитоор тайлагнаагүй байна.	1	1,150.0			1	1,150.0						
Тайлант онд байгууллагын жолоочид шалгуур үзүүлэлтийн дагуу бодитой үнэлэлгүй 3,041.7 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон байна.	1	3,041.7					1	3,041.7				
Дүн	2	4,191.7			1	1,150.0	1	3,041.7				